



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК

2026 оны 03 дугаар сарын 11

Багануур дүүрэг

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

- Паркийн 100 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 6.76 км агаарын шугамыг хамтран хэрэгжүүлэхээр Месес ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн авсан.

- Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын шийдвэрлэсэн.

Нийслэлийн засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1130 захирамжаар паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил, Паркийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинэчлэн боловсруулах 80.0 сая.төг-ийг шийдвэрлэсэн.

Паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахаар Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв НҮТББ шалгарч нийслэлийн Засаг даргын Тамгын газартай 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн НХААГ/20250203701 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Паркийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинэчлэн боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Нийслэлийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн А/100 захирамжаар Паркийн үйлдвэрийн албан конторын барилгын засварын зураг төслийн 46.8 сая.төг санхүүжилт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Нийслэлийн засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/268 захирамжаар Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн ХЕТ-ний зураг төслийн 298.6 сая.төг санхүүжилт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

Мэдээлэл өгөх ажилтан:
Үйлдвэрлэл, технологийн хэлтсийн
дарга Б.Мөнгөнхуяг.
Утас: 88656964